

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал зарлан хуралдуулах тухай

Компанийн тухай хуулийн 59.4, 60.1, 60.2, 60.3, 76.1.2 дахь заалтыг үндэслэн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Хурлаас ТОГТООХ нь:

1. "Хөвсгөл алтан дуулга" ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2022 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 11.00 цагт Хөвсгөл аймаг, Тариалан сум, Мандал багт байрлах "Хөвсгөл алтан дуулга" ХК-ийн байранд хуралдуулсугай.

2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлуудыг хэлэлцүүлсүгэй.

- Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг батлах тухай
- Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг улируулан сонгох тухай
- Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны зардлын тоовийг батлах тухай
- Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллын тухай
- "Ногдол ашиг хуваарилахгүй байх тухай" ТУЗ-ийн 2022 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн 01 дүгээр тогтоолыг танилцуулах

3. Компанийн тухай хуулийн 64.2-т заасны дагуу Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2022 оны 04 дүгээр сарын 05-ны өдрөөр тогтоосугай.

4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Д.Батхуягийг, хурал зохион байгуулах комиссын даргаар Компанийн Гүйцэтгэх захирал Н.Одончимэгийг томилсугай.

5. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хуралдуулах шийдвэр гарсантай холбогдуулан хурлын зарыг 2022 оны 03 дугаар сарын 21-ний өдөр Монголын хөрөнгийн биржийн цахим хуудас, компанийн өөрийн цахим хуудсаар, 2022 оны 03 дугаар сарын 22-ны өдөр "Өдрийн сонин", "Өнөөдөр" сониноор дамжуулан хувьцаа эзэмшигчдэд мэдээлсүгэй.

6. Хурлын зар мэдээг анхны мэдээлсэн өдрөөс хойш 15 хоногийн дараа өмнө нь мэдээлсэн хэлбэрийн дагуу дахин мэдээлэхийг хурал зохион байгуулах комисст даалгасугай.

7. Хувьцаа эзэмшигч нь энэхүү тогтоолын 1 дүгээр хавсралтад заасан бичиг баримтыг ажлын өдрүүдэд 10.00-17.00 цагийн хооронд Улаанбаатар хот, 8 дугаар хороо, 11 дүгээр хороолол, Ж.Батмөнхийн гудамж 39-2, "Велокс" оффисын

8 давхарт болон Хөвсгөл аймгийн Тариалан суманд байрлах компанийн байранд ирж танилцаж болохыг дурьдсугай.

9. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэх баримт бичгийн бэлэн болгох эцсийн хугацааг 2022 оны 03 дугаар сарын 21-ний өдрөөр тогтоосугай.

10. Тус компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдийн танилцах бичиг баримтын жагсаалт, хэлэлцэх асуудлаар санал өгөх "Саналын хуудас"-ны агуулгыг 1, 2 дугаар хавсралтаар баталсугай.

11. Хувьцаа эзэмшигчдийн урьдчилж өгөх саналын хуудсыг хүлээн авах сүүлчийн өдрийг 2022 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн 11:00 цаг байхаар тогтсугай.

12. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын даргаар Компанийн нягтлан бодогч Ш.Батцэнгэл, гишүүдээр Компанийн хүний нөөцийн менежер Г.Мөнхзаяа, тооцооны нягтлан бодогч Б.Юмжирдулам нарыг тус тус томилсугай.

